УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Тариалан сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** УВА-2026/144/НА-СТА-ТШЗ

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Улаангом хот<br>2026 он | Увс аймаг дахь Төрийн аудитын газар,<br>Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь<br>Утас: 70453317, Цахим хаяг: BatsuuriM@audit.gov.mn<br>Аудитын менежер: М.Бат-Амгалан<br>Утас: 70453799, Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn<br>Аудитор: Р.Аюуш<br>Утас: 70453721, Цахим хаяг: Ayushr@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга


**1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ**

**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ** .....5

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....5

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....6

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....8

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....10

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....11

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....12

**3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....13

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин .....13

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....14

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд .....14

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....15

3.5.1 Төсвийн төлөвлөлт.....15

3.5.2 Төсвийн гүйцэтгэл.....15

3.5.3 Нэмэлт төсөв .....16

**4. АУДИТЫН ТАЙЛАН** .....16

4.1 Ерөнхий зүйл.....16

4.2 Материаллаг байдал.....17

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....17

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....17

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....17

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд .....18

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....18

4.5.1 Завсрын аудитын талаар.....18

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн.....18

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....18

**5.АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ**.....18

5. Залруулсан алдаа.....19

**6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ** .....19


**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |

**УВС АЙМАГ ДАХЬ**
**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
213400, Увс аймаг, Улаангом сум,
Ө.Бадрахын гудамж
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,
E-mail: uvs@audit.gov.mn

2026.02.25 № УВА-2026/144/НА-СТА-ТЧЗ
танай______________-ны №________________-т

ТАРИАЛАН СУМЫН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА Б.МЭНГЭЭ ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Тариалан сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Тариалан сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

АДБОУС 2706.7-д тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

**Аудитын гол асуудал**

АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

**Бусад асуудлын хэсэг**

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад санхүүгийн тайлангийн тодруулга толилуулгад тусгаагүй, аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй асуудал гараагүй болно.

8575050251

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.
Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР М.БАТСУУРЬ

9065555 1525010041

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1. Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөг/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **188,846,965.40** | **376,119,346.41** |
| **33** | **АВЛАГА** | - | 23,503,361.71 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | - | 5,503,361.71 |
| **335** | **Бусад авлага** | - | 18,000,000.00 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | - | 18,000,000.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 188,846,965.40 | 352,615,984.70 |
| **354** | **Хангамжийн материал** | 180,852,299.40 | 340,621,318.70 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 2,081,800.00 | 696,500.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 24,644,035.00 | 118,132,000.00 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 6,973,000.00 | 5,280,000.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 147,153,464.40 | 216,512,818.70 |
| 35600 | Мал амьтад | 7,994,666.00 | 11,994,666.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **3,800,576,425.63** | **5,035,137,068.35** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 3,800,576,425.63 | 5,035,137,068.35 |
| **392** | **Биет хөрөнгө** | 2,910,886,425.63 | 4,142,447,068.35 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 1,863,955,864.00 | 1,926,394,343.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (225,776,412.27) | (302,904,256.47) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 469,752,193.00 | 467,802,193.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (110,746,816.25) | (161,193,967.37) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 357,370,785.50 | 360,897,282.93 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (150,132,172.49) | (169,649,501.39) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 61,119,214.00 | 83,653,414.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (42,430,230.43) | (43,170,143.81) |
| 39209 | Зам, гүүрний байгууламж | 197,184,974.00 | 197,184,974.00 |
| 39210 | Хуримтлагдсан элэгдэл | (197,184,974.00) | (197,184,974.00) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 1,129,121,502.05 | 2,559,966,922.05 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (441,404,028.48) | (579,405,744.59) |
| 39217 | Ном | 56,527.00 | 56,527.00 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 889,690,000.00 | 892,690,000.00 |
| 39301 | Программ хангамж | 2,020,000.00 | 5,020,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (2,020,000.00) | (2,020,000.00) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 913,690,000.00 | 913,690,000.00 |
| 39304 | Хуримтлагдсан элэгдэл | (24,000,000.00) | (24,000,000.00) |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **3,989,423,391.03** | **5,411,256,414.76** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **7,048,416.27** | **37,431,101.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 7,048,416.27 | 37,431,101.00 |
| **413** | **Өглөг** | 7,048,416.27 | 37,431,101.00 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 2,488,475.02 | 5,969,231.00 |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | 4,559,941.25 | 8,324,070.00 |
| **4136** | **Бусад өглөг** | - | 23,137,800.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | - | 7,477,800.00 |
| 41362 | Хувь хүмүүст төлөх өглөг | - | 15,660,000.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **3,982,374,974.76** | **5,374,059,654.92** |

| | | | |
|---|---|---|---|
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 3,982,374,974.76 | 5,373,825,313.76 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 327,375,075.15 | 327,375,075.15 |
| 51101 | Өмч: - төрийн | 327,375,075.15 | 327,375,075.15 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 3,345,988,045.34 | 4,740,688,387.34 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 3,345,988,045.34 | 3,349,238,048.34 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | 1,391,450,339.00 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 309,011,854.27 | 305,761,851.27 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **3,989,423,391.03** | **5,411,256,414.76** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөг/

| **Данс** | **Үзүүлэлт** | **Өмнөх он** | **Тайлант он** |
|---|---|---|---|
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 1,170,891,107.00 | 1,506,686,722.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | | |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | | |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 72,970,207.00 | 262,862,022.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 23,958,719.00 | 7,250,000.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 32,718,500.00 | 250,500,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 200,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 16,292,988.00 | 4,912,022.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 1,097,920,900.00 | **1,243,824,700.00** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 1,097,920,900.00 | 1,243,824,700.00 |
| 1340 | Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих | | |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 1,559,267,881.55 | 1,561,005,009.23 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 1,559,267,881.55 | 1,561,005,009.23 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 1,559,267,881.55 | 43,570,203.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 11,568,417.50 | 19,335,178.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 1,547,699,464.05 | 24,235,025.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | | 1,345,899,881.93 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | | 171,534,924.30 |
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | **2,730,158,988.55** | **3,067,691,731.23** |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,574,341,528.23 | 1,675,887,051.54 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,494,425,154.77 | 1,539,422955.63 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 669,292,230.00 | 803,338,939.00 |
| 210101 | Үндсэн цалин | 404,594,676.00 | 445,481,877.00 |
| 210102 | Нэмэгдэл | 225,107,400.00 | 299,544,789.00 |
| 210104 | Урамшуулал | | 12,604,750.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 39,590,154.00 | 45,707,523.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 83,272,105.38 | 100,504,054.80 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 56,528,660.16 | 68,398,806.77 |

| | | | |
|---|---|---|---|
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 6,684,948.36 | 8,064,569.31 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,544,116.89 | 4,106,955.35 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 3,302,874.25 | 3,986,744.75 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 13,211,505.72 | 15,946,978.62 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 134,896,458.18 | 142,066,197.55 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 11,089,706.85 | 15,341,884.66 |
| 210302 | Түлш, халаалт | 123,806,751.33 | 126,724,312.89 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 69,764,197.00 | 33,683,410.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 5,032,630.00 | 4,236,100.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 62,872,527.00 | 27,448,560.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,376,540.00 | 1,843,500.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 482,500.00 | 155,250.00 |
| 2105 | Нормативт зардал | 460,000.00 | |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 460,000.00 | |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 22,855,151.00 | 57,386,350.00 |
| 210604 | Урсгал засвар | 22,855,151.00 | 57,386,350.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 7,030,000.00 | 5,470,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 7,030,000.00 | 5,470,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 3,215,991.50 | 2,787,810.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,180,230.00 | 1,065,500.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 300,000.00 | 288,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 360,000.00 | |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 407,761.50 | 133,896.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 66,000.00 | |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 462,000.00 | 437,500.00 |
| 210807 | Газрын төлбөр | 440,000.00 | 862,914.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 503,639,021.71 | 394,186,194.28 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 104,517,300.00 | 41,506,955.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 2,143,000.00 | 2,000,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 396,978,721.71 | 350,679,239.28 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 79,916,373.46 | 136,698,436.67 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 31,161,395.00 | |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 28,961,395.00 | |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 2,200,000.00 | |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 48,754,978.46 | 136,698,436.67 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 46,660,657.46 | 118,613,436.67 |
| 213405 | Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | 2,094,321.00 | 18,085,000.00 |
| II | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 1,574,341,528.23 | 1,676,121,392.30 |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2) | 1,155,817,460.32 | 1,391,570,338.93 |
| 145 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН | | |
| 225 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | | 119,999.93 |
| 225010 | Үнэ төлбөргүй гарсан зардал - Үндсэн хөрөнгө | | 119,999.93 |
| IV | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225) | | -119,999.93 |
| V | НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4) | 1,155,817,460.32 | 1,391,450,339.00 |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөг/

| Данс | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1) | 1,182,459,524.50 | 1,526,021,900.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 11,568,417.50 | 19,335,178.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 11,568,417.50 | 19,335,178.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 11,568,417.50 | 19,335,178.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 11,568,417.50 | 19,335,178.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 1,170,891,107.00 | 1,506,686,722.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 72,970,207.00 | 262,862,022.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 23,958,719.00 | 7,250,000.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 32,675,000.00 | 250,500,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 16,336,488.00 | 5,112,022.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 1,097,920,900.00 | 1,243,824,700.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 1,097,920,900.00 | 1,243,824,700.00 |
| II | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2) | 1,182,459,524.50 | 1,286,561,900.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,182,459,524.50 | 1,286,561,900.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,102,543,151.04 | 1,149,863,463.33 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 666,778,728.00 | 805,025,659.00 |
| 210101 | Үндсэн цалин | 406,498,982.00 | 453,461,864.00 |
| 210102 | Нэмэгдэл | 220,679,746.00 | 293,374,140.00 |
| 210104 | Урамшуулал | | 12,690,500.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 39,600,000.00 | 45,499,155.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 83,297,132.36 | 100,821,440.53 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 56,880,704.87 | 68,760,209.06 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 6,655,229.33 | 8,053,565.17 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,348,783.27 | 4,101,453.28 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 3,260,013.23 | 3,981,242.68 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 13,152,401.66 | 15,924,970.34 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 134,565,406.18 | 122,991,113.80 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 11,089,706.85 | 15,341,884.66 |
| 210302 | Түлш, халаалт | 123,475,699.33 | 107,649,229.14 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 59,849,017.00 | 24,010,290.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 4,806,080.00 | 2,040,800.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 52,486,897.00 | 19,971,790.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,376,540.00 | 1,743,500.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 700,000.00 | 73,200.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 479,500.00 | 181,000.00 |
| 2105 | Нормативт зардал | 460,000.00 | |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 460,000.00 | |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 35,778,296.00 | 65,574,650.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 8,317,300.00 | |
| 210604 | Урсгал засвар | 27,460,996.00 | 65,574,650.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 7,030,000.00 | 5,470,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 7,030,000.00 | 5,470,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 3,797,991.50 | 2,887,810.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,762,230.00 | 1,165,500.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 300,000.00 | 288,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 360,000.00 | |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 407,761.50 | 133,896.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 66,000.00 | |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 462,000.00 | 437,500.00 |
| 210807 | Газрын төлбөр | 440,000.00 | 862,914.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 110,986,580.00 | 23,082,500.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 108,843,580.00 | 23,082,500.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 2,143,000.00 | |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 79,916,373.46 | 136,698,436.67 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 31,161,395.00 | |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 28,961,395.00 | |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 2,200,000.00 | |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 48,754,978.46 | 136,698,436.67 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 46,660,657.46 | 118,613,436.67 |
| 213405 | Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | 2,094,321.00 | 18,085,000.00 |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2) | | 239,460,000.00 |
| V | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5) | | 239,460,000.00 |
| | Дотоод эх үүсвэрээр | | 239,460,000.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | | 239,460,000.00 |
| VI | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5) | | -239,460,000.00 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөг/

| Дансны код | Дансны нэр, төрөл | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан үр дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| 1 | 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 327,375,075.15 | 314,700,607.73 | 2,188,068,060.81 | 2,830,143,743.69 |
| 2 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | 5,688,753.46 | 5,688,753.46 |
| 3 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 327,375,075.15 | 314,700,607.73 | 2,193,756,814.27 | 2,835,832,497.15 |
| 4 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | - | (5,688,753.46) | - | (5,688,753.46) |
| 9 | Тайлант үеийн үр дүн | - | - | 1,152,231,231.07 | 1,152,231,231.07 |
| 10 | 2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 327,375,075.15 | 309,011,854.27 | 3,345,988,045.34 | 3,982,374,974.76 |
| 11 | 2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 327,375,075.15 | 309,011,854.27 | 3,345,988,045.34 | 3,982,374,974.76 |
| 12 | 1.1.2 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | 3,250,003.00 | 3,250,003.00 |
| 13 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 327,375,075.15 | 309,011,854.27 | 3,349,238,048.34 | 3,985,624,977.76 |
| 15 | Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт | - | (3,250,003.00) | - | (3,250,003.00) |
| 19 | 1.7 Тайлант үеийн үр дүн | - | - | 1,391,450,339.00 | 1,391,450,339.00 |
| 20 | 1 2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл | 327,375,075.15 | 305,761,851.27 | 4,740,688,387.34 | 5,373,825,313.76 |

## 5. Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөг/

| Дансны код | Дансны нэр, төрөл | 1. Төлөвлөгөө | 2. Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| 1 | 3.1.01.1 НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН | 1,036,068,900.00 | 1,144,546,441.33 |
| 12 | 3.1.01.1.2 Татварын бус орлого | 1,036,068,900.00 | 1,144,546,441.33 |
| 120 | 3.1.01.1.2.1 Нийтлэг татварын бус орлого | 44,800,000.00 | 19,335,178.00 |
| 120004 | 3.1.01.1.2.1.4 Төсөв байгууллагын өөрийн орлого /үндсэн/ | 44,800,000.00 | 19,335,178.00 |
| 122 | 3.1.01.1.2.3 Тусламжийн орлого | 991,268,900.00 | 1,125,211,263.33 |
| 122005 | 3.1.01.1.2.3.5 Төсвөөс санхүүжих | 991,268,900.00 | 1,125,211,263.33 |
| II | 3.1.01.2 НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 1,288,624,700.00 | 1,144,546,441.33 |
| 21 | 3.1.01.2.1 УРСГАЛ ЗАРДАЛ | 1,288,624,700.00 | 1,144,546,441.33 |
| 210 | 3.1.01.2.1.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,285,624,700.00 | 1,144,546,441.33 |
| 2101 | 3.1.01.2.1.1.1 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 844,904,600.00 | 804,168,159.00 |
| 210101 | 3.1.01.2.1.1.1.01 Үндсэн цалин | 799,364,600.00 | 453,461,864.00 |
| 210102 | 3.1.01.2.1.1.1.02 Нэмэгдэл | - | 293,374,140.00 |
| 210104 | 3.1.01.2.1.1.1.04 Урамшуулал | - | 11,833,000.00 |
| 210105 | 3.1.01.2.1.1.1.05 Гэрээт ажлын хөлс | 45,540,000.00 | 45,499,155.00 |
| 2102 | 3.1.01.2.1.1.2 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 105,613,100.00 | 100,722,828.53 |
| 210201 | 3.1.01.2.1.1.2.01 Тэтгэврийн даатгал | 71,817,000.00 | 68,661,597.06 |
| 210202 | 3.1.01.2.1.1.2.02 Тэтгэмжийн даатгал | 8,449,000.00 | 8,053,565.17 |
| 210203 | 3.1.01.2.1.1.2.03 ҮОМШӨ-ний даатгал | 4,224,500.00 | 4,101,453.28 |
| 210204 | 3.1.01.2.1.1.2.04 Ажилгүйдлийн даатгал | 4,224,500.00 | 3,981,242.68 |
| 210205 | 3.1.01.2.1.1.2.05 Эрүүл мэндийн даатгал | 16,898,100.00 | 15,924,970.34 |
| 2103 | 3.1.01.2.1.1.3 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 136,317,700.00 | 122,991,113.80 |
| 210301 | 3.1.01.2.1.1.3.01 Гэрэл, цахилгаан | 29,328,500.00 | 15,341,884.66 |
| 210302 | 3.1.01.2.1.1.3.02 Түлш, халаалт | 106,989,200.00 | 107,649,229.14 |
| 2104 | 3.1.01.2.1.1.4 Хангамж, бараа материалын зардал | 34,109,000.00 | 20,069,380.00 |
| 210401 | 3.1.01.2.1.1.4.01 Бичиг хэрэг | 2,897,400.00 | 2,040,800.00 |
| 210402 | 3.1.01.2.1.1.4.02 Тээвэр, шатахуун | 27,382,600.00 | 16,030,880.00 |
| 210403 | 3.1.01.2.1.1.4.03 Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,830,000.00 | 1,743,500.00 |
| 210405 | 3.1.01.2.1.1.4.05 Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 450,000.00 | 73,200.00 |
| 210406 | 3.1.01.2.1.1.4.06 Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 549,000.00 | 181,000.00 |
| 2105 | 3.1.01.2.1.1.5 Нормативт зардал | 414,000.00 | - |
| 210503 | 3.1.01.2.1.1.5.03 Нормын хувцас, зөөлөн эдлэл | 414,000.00 | - |
| 2106 | 3.1.01.2.1.1.6 Эд хогшил, урсгал засварын зардал | 96,488,700.00 | 59,154,650.00 |
| 210601 | 3.1.01.2.1.1.6.01 Багаж, техник, хэрэгсэл | 900,000.00 | - |
| 210604 | 3.1.01.2.1.1.6.04 Урсгал засвар | 95,588,700.00 | 59,154,650.00 |
| 2107 | 3.1.01.2.1.1.7 Томилолт, зочны зардал | 7,298,600.00 | 5,470,000.00 |
| 210702 | 3.1.01.2.1.1.7.02 Дотоод албан томилолт | 7,298,600.00 | 5,470,000.00 |
| 2108 | 3.1.01.2.1.1.8 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 12,536,000.00 | 5,887,810.00 |
| 210801 | 3.1.01.2.1.1.8.01 Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 5,776,000.00 | 1,165,500.00 |
| 210802 | 3.1.01.2.1.1.8.02 Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 420,000.00 | 288,000.00 |
| 210803 | 3.1.01.2.1.1.8.03 Даатгалын үйлчилгээ | 420,000.00 | - |
| 210804 | 3.1.01.2.1.1.8.04 Тээврийн хэрэгслийн татвар | 360,000.00 | 133,896.00 |
| 210805 | 3.1.01.2.1.1.8.05 Тээврийн хэрэгслийн оношилгоо | 480,000.00 | - |
| 210806 | 3.1.01.2.1.1.8.06 Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 4,080,000.00 | 3,437,500.00 |
| 210807 | 3.1.01.2.1.1.8.07 Газрын төлбөр | 1,000,000.00 | 862,914.00 |
| 2109 | 3.1.01.2.1.1.9 Бараа үйлчилгээний бусад зардал | 47,943,000.00 | 26,082,500.00 |
| 210901 | 3.1.01.2.1.1.9.01 Бараа үйлчилгээний бусад зардал | 47,093,000.00 | 26,082,500.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210902 | 3.1.01.2.1.1.9.02 Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 850,000.00 | - |
| 213 | 3.1.01.2.1.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 3,000,000.00 | - |
| 2132 | 3.1.01.2.1.4.2 Бусад урсгал шилжүүлэг | 3,000,000.00 | - |
| 213209 | 3.1.01.2.1.4.2.08 Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 3,000,000.00 | - |
| 8 | 3.1.01 ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ | (252,555,800.00) | - |
| 9 | 3.1 АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 252,555,800.00 | - |
| 7 | 3 Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт | 252,555,800.00 | - |
| 6 | 6 ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ | 61.00 | 61.00 |
| 61 | 6.1 БАЙГУУЛЛАГЫН ТОО | 1.00 | 1.00 |
| 610001 | 6.1.01 Төсвийн байгууллага | 1.00 | 1.00 |
| 62 | 6.2 АЖИЛЛАГСДЫН ТОО | 30.00 | 30.00 |
| 620001 | 6.2.01 Удирдах ажилтан | 9.00 | 9.00 |
| 620002 | 6.2.02 Гүйцэтгэх ажилтан | 10.00 | 8.00 |
| 620003 | 6.2.03 Үйлчлэх ажилтан | 3.00 | 8.00 |
| 620004 | 6.2.04 Гэрээт ажилтан | 8.00 | 5.00 |
| 65 | 6.5 ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ | 30.00 | 30.00 |
| 650001 | 6.5.01 Төрийн захиргааны албан хаагч (ТЗ) | 10.00 | 9.00 |
| 650009 | 6.5.09 Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 7.00 | 8.00 |
| 650010 | 6.5.10 Гэрээт ажилтан | 5.00 | 5.00 |
| 650011 | 6.5.11 Улс төрийн албан хаагч (УТ) | 8.00 | 8.00 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлтийн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөг/

| Дансны код | Дансны нэр, төрөл | 1. Тайлант он |
|---|---|---|
| 1 | 1.1.1.1 НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН | 262,862,022.00 |
| 12 | 1.1.1.1.1 ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 262,862,022.00 |
| 122 | 1.1.1.1.1.1 Тусламжийн орлого | 262,862,022.00 |
| 1221 | 1.1.1.1.1.1.1 Хандив тусламж /дотоод/ | 262,862,022.00 |
| 12213 | 1.1.1.1.1.1.1.1 Нэмэлт санхүүжилтийн орлого | 262,862,022.00 |
| 350011 | 1.1.1.1.1.1.1.1.1 Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 7,250,000.00 |
| 350013 | 1.1.1.1.1.1.1.1.3 ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 250,500,000.00 |
| 350015 | 1.1.1.1.1.1.1.1.5 Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 5,112,022.00 |
| II | 1.1.1.2 НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 244,777,022.00 |
| 21 | 1.1.1.2.1 УРСГАЛ ЗАРДАЛ | 36,277,022.00 |
| 210 | 1.1.1.2.1.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 36,277,022.00 |
| 2101 | 1.1.1.2.1.1.1 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 857,500.00 |
| 210104 | 1.1.1.2.1.1.1.4 Урамшуулал | 857,500.00 |
| 2102 | 1.1.1.2.1.1.2 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 98,612.00 |
| 210201 | 1.1.1.2.1.1.2.1 Тэтгэврийн даатгал | 98,612.00 |
| 2104 | 1.1.1.2.1.1.4 Хангамж, бараа материалын зардал | 3,940,910.00 |
| 210402 | 1.1.1.2.1.1.4.2 Тээвэр, шатахуун | 3,940,910.00 |
| 2106 | 1.1.1.2.1.1.6 Эд хогшил, урсгал засварын зардал | 29,880,000.00 |
| 210602 | 1.1.1.2.1.1.6.2 Тавилга | 19,880,000.00 |
| 210604 | 1.1.1.2.1.1.6.4 Урсгал засвар | 10,000,000.00 |
| 2109 | 1.1.1.2.1.1.9 Бараа үйлчилгээний бусад зардал | 1,500,000.00 |
| 210901 | 1.1.1.2.1.1.9.1 Бараа үйлчилгээний бусад зардал | 1,500,000.00 |
| 22 | 1.1.1.2.2 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 208,500,000.00 |
| 2200 | 1.1.1.2.2.1 Дотоод эх үүсвэрээр | 208,500,000.00 |
| 223001 | 1.1.1.2.2.1.4 Бусад хөрөнгө | 208,500,000.00 |
| 4 | 1.1.1 ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ | 18,085,000.00 |
| 5 | 1.1 АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | (18,085,000.00) |
| 6 | 1 Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт | (18,085,000.00) |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Орон нутгийн удирдлагыг мэдээлэл, бодлогын удирдамжаар ханган хууль тогтоомж, хөтөлбөрийн хэрэгжилтийг зохицуулан сумын эдийн засаг, нийгмийн хөгжлийг хангаж, төрийн үйлчилгээг иргэдэд ил тод нээлттэй, чанар, хүртээмжтэй хүргэх зорилготой байгууллага юм.

Тамгын газрын чиг үүргийн хувьд орон нутагт төрийн захиргааны удирдлага, төлөвлөлт санхүү, эдийн засгийн бодлого, нийгмийн бодлогын асуудлыг хариуцан төрийн хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, түүний хэрэгжилтийг хангуулах төрөөс иргэдэд үзүүлэх үйлчилгээг хуулийн дагуу түргэн шуурхай, чанартай хүргэх, иргэдийн ажиллаж амьдрах таатай орчин бүрдүүлэхэд гол анхаарал хандуулан ажиллаж байна.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тариалан сумын Засаг даргын тамгын газрын удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг явуулж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- ✓ Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт үндэсний хорооны 2024 оны 10 дугаар сарын 7-ны өдрийн 3 дугаар тогтоолоор улсын хэмжээнд мөрдөх хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн сард 792.0 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоосон.
- ✓ Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 238 дугаар тогтоолоор Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон.
- ✓ Сангийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн А/3 дугаар тогтоолоор батлагдсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"
- ✓ Төрийн хэмнэлтийн тухай хуульд - 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр, 2024 оны 06 дугаар сарын 16-ны өдөр, 07 дугаар сарын 07-ны өдөр, 2024 оны 12 дугаар сарын 12-ны өдөр,

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэхэд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна. Төсвийн ерөнхийлөн захирагчаас эрсдэлд суурилсан дотоод аудит хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ

илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Тариалан сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлсөн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

## 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Увс аймгийн Тариалан сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,422,067.4 мянган төгрөгөөр буюу 10.8 хувиар өссөн байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Авлага | - | 23,503.3 | 23,503.3 |
| Бараа материал | 188,847.0 | 352,616.0 | 163,769.0 |
| Үндсэн хөрөнгө | 3,800,576.4 | 5,035,137.1 | 1,234,560.7 |
| **Нийт хөрөнгө** | **3,989,423.4** | **5,411,256.4** | **1,421,833.0** |
| Өглөг | 7,048.4 | 37,431.1 | 30,382.7 |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 3,982,375.0 | 5,373,825.3 | 1,391,450.3 |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **,989,423.4** | **5,411,256.4** | **1,421,833.0** |

Тайлант оны эхэнд болон эцэст мөнгөн хөрөнгийн данс үлдэгдэлгүй байна.

Авлага дансны үлдэгдэл 23,503.3 мянган төгрөг болж өссөн нь нэмэлт санхүүжилтийн дансны татуулсан төсвийг авлагаар тусган буцаан авч өр төлбөр барагдуулахаар авлага үүсгэсэн байна.

Бараа материал дансны үлдэгдэл 352,616.0 мянган төгрөг болж 163,769.0 мянган төгрөгөөр өссөн төсвийн хөрөнгөөр 99,944.0 мянган төгрөгийн бараа материал бэлтгэн, 171,534.9 мянган төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүй хүлээн авч, 107,710.0 мянган төгрөгийн бараа материал зарцуулсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн данс нь 5,035,137.1 мянган төгрөг болж 1,234,560.7 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 239,460.0 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авч, 1,345,899.9 мянган төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүй хүлээн авч, тайлант онд 350,679.2 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал тооцож, 64,965.3 мянган төгрөгийн хөрөнгө акталсантай холбоотой байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 37,431.1 мянга болж 30,382.7 мянган төгрөгөөр өссөн нь тайлант оны санхүүжилтийн зарцуулалтын эрхийг хязгаарласнаас байгууллагын хэвийн үйл ажиллагаа явуулахад үүссэн өглөг байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 5,373,825.3 мянган төгрөг болж 1,391,450.3 мянган төгрөгөөр өссөн нь тайлан үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 844,667.6 мянга, үндсэн үйл ажиллагааны орлогоос 21,000.0 мянга, урьд оны үлдэгдлээс 70,000.0 мянга, нийт зарлагыг 935,667.6 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас нийт зардлыг 380,613.9 мянган төгрөгөөр өсгөн 1,316,281.5 мянган төгрөгөөр баталсан байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 27,656.8 мянган төгрөгөөр бууруулан 1,288,624.7 мянган төгрөгөөр тодотгон баталсан байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 3 хөтөлбөрийн 12 арга хэмжээг санхүүжүүлэхээр орон нутгийн төсвөөс 1,243,824.7 мянга, үндсэн үйл ажиллагааны орлогоос 44,800.0 мянган төгрөгийг бүрдүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 1,125,211.3 мянга, үндсэн үйл ажиллагааны орлогоос 19,335.2 мянга, нийт 1,144,546.4 мянган төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Тайлант оны батлагдсан үндсэн үйл ажиллагааны орлогоос 25,464.8 мянган төгрөгийг дутуу санхүүжилт төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,144,546.4 мянган төгрөг буюу 88.8 хувьтай байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

| № | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| 1 | Үндсэн үйл ажиллагааны зардал /80101 / | 747,954.6 | 668,222.3 | 79,732.3 | 89.3% |
| 2 | Баг хорооны үйл ажиллагааны зардал /80106 / | 272,952.4 | 247,721.0 | 25,231.4 | 90.8% |
| 3 | Төрийн өмчийн барилгын тогтмол зардал /80111 / | 144,183.7 | 130,577.0 | 13,606.7 | 90.6% |
| 4 | Нийтлэг үйлчилгээ /80111/ | 71,791.0 | 71,620.5 | 170.5 | 99.8% |
| 5 | Мэдээлэл сурталчилгааны зардал / 80205 / | 1,200.0 | 250.0 | 950.0 | 20.8% |
| 6 | Ажил олгогчоос олгох тэтгэмж /80802 / | 3,000.0 | 0.0 | 3,000.0 | 0.0% |
| 7 | Орон нутгийн нөөц хөрөнгө /81102 / | 26,000.0 | 19,278.0 | 6,722.0 | 74.1% |
| 8 | Мал тооллого /81507 / | 3,400.0 | 0.0 | 3,400.0 | 0.0% |
| 9 | Хур хог хаягдал орчны бохирдол /82212 / | 450.0 | 73.2 | 376.8 | 16.3% |
| 10 | Улсын их баяр наадам /82801 / | 5,000.0 | 0.0 | 5,000.0 | 0.0% |
| 11 | Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх /71413 / байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх /81701 / | 11,493.0 | 6,004.4 | 5,488.6 | 52.2% |
| 12 | Ахмад настны хөгжил хамгаалал /72208 / ахмадын сан / 81549 / | 1,200.0 | 800.0 | 400.0 | 66.7% |
| | Дүн | 1,288,624.7 | 1,144,546.4 | 144,078.3 | |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

**Аудитын ерөнхий чиглэлийн судалгааны дүн**

1. Программ хангамжийн судалгаа

/мянган төгрөгөөр/

| Д/д | Программ, лиценз нийлүүлсэн байгууллагын нэр | Санхүүгийн тайланд бүртгэлтэй эсэх /тийм, үгүй/ | Зориулалт | Тайланд онд гэрээний дагуу төлсөн төлбөр | Ашиглагдахгүй байгаа программ хангамжийн тайлбар |
|---|---|---|---|---|---|
| 1 | Сум хөгжүүлэх сангийн программ | Тийм | Зээлийн мэдээлэл | 150.0 | Ашиглаж байгаа |
| 2 | Acoelous программ | Тийм | Бүртгэл санхүү | 437.5 | Шинээр онлайн программ нэвтэрсэн. |
| 3 | Бичиг хэргийн программ | Тийм | Архив бичиг хэрэг | | Егр систем шинэчлэгдсэн тул давхар бүртгэх шаардлагагүй болсон. |
| 4 | Нэгтгэлийн программ | Тийм | Санхүүгийн тайлан | | Э-Тайлангаар нэгтгэл шивдэг болсон. |
| 5 | CTS-Санхүүгийн онлайн программ | Үгүй | Бүртгэл санхүү | 3,000.0 | Тайлант онд шинээр худалдан авсан. |
| 6 | Няравын онлайн программ | Үгүй | Санхүүгийн анхан шатны бүртгэл | | |
| | Нийт дүн | | | 3,587.5 | |

2. Унаа, хоол, сургалт семинарын орон тооны судалгаа

/мянган төгрөг/

| № | Үзүүлэлт | Төсөвлөсөн | Гүйцэтгэл | Зөрүү | Тайлбар |
|---|---|---|---|---|---|
| 1 | Унаа, хоолны зардал | 0.00 | 0.00 | 0.00 | Хоол унааны зардал гараагүй болно. |
| 2 | Сургалт, семинар, хурал, зөвлөгөөний зардал | 0.00 | 0.00 | 0.00 | Сургалт, семинар, хурал, зөвлөгөөний зардал |
| 3 | Гадаад томилолт, арга хэмжээ | 0.00 | 0.00 | 0.00 | Гадаад томилолт, арга хэмжээ зардал гараагүй байна. |
| 4 | Төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой зардал | 0.00 | 0.00 | 0.00 | Төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой зардал гараагүй байна. |
| 5 | Орон тоо | 25 | 30 | 0.00 | ЗДТГ-ын сахиул-1, машинист-1, багийн сахиул гэрээт-4 гэсэн орон тоог ЗДТГ-ын даргын тушаалаар батлан ажиллуулсан байна. |
| 6 | Хэвлэл мэдээлэл | 1200.0 | 250.0 | 950.0 | Хэвлэл мэдээлэлтэй холбоотой зардал гараагүй байна. |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгөөс 250,500.0 мянга, Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгөөс 200.0 мянга, Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламжаас 7,250.0 мянга, Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоос 4,912.0 мянга, нийт 262,862.0 мянган төгрөгийн орлого орсон байна. Үүнээс: урсгал зардалд 32,902.0 мянга, хөрөнгийн зардалд 229,960.0 мянган төгрөгийг тус тус зарцуулж, 18,085.0 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.5.3 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тариалан сумын Засаг даргын тамгын газар нь тайлант онд хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр байхгүй байна.

### 3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тариалан сумын Засаг даргын тамгын газар нь тайлант онд тендер зарласан үйл ажиллагаа байхгүй байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана" гэж заасны дагуу Тариалан сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Р.Аюуш гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Тариалан сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн 05 дугаар албан бичгээр ирүүлсэн.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг "Дунд" гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1,577,927.8 мянган төгрөгийн 1 хувиар буюу 15,779.3 мянган төгрөгөөс 80 хувиар тооцож 12,623.4 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлыг 2025 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,675,887.1 мянган төгрөгийн 1 хувиар буюу 16,758.9 мянган төгрөгөөс 80 хувиар тооцож 13,407.1 мянган төгрөгөөр тогтоосон.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Тариалан сумын Засаг даргын тамгын газрын тухайн хуульд хамаарах зүйл заалтын хүрээнд горим сорил хэрэгжүүлэн ажиллахад алдаа, зөрчил илэрсэнгүй.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тариалан сумын Засаг даргын тамгын газар нь тайлант хугацаанд www.shilendans.gov.mn цахим хуудсанд оруулбал зохих 171 мэдээллээс хугацаандаа оруулсан 163, хугацаа хоцорсон 3, хугацаа болоогүй 5 мэдээлэл байна.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Төрийн аудитын байгууллагаас 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлангийн аудитаар баримтлах ерөнхий чиглэлд тусгагдсан болон бусад хууль тогтоомжтой холбоотой хэрэгжүүлсэн ажиллахад алдаа, зөрчил илэрсэнгүй.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

#### 4.5.1 Завсрын аудитын талаар

Тариалан сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны санхүүгийн тайланд завсрын аудитаар алдаа зөрчил илрээгүй болно.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 52,486.9 мянган төгрөгийн 1 зөвлөмж өгснийг биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн 48 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

*Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт*

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Акт | | | | | |
| Албан шаардлага | | | | | |
| Зөвлөмж | 1 | 52,486.9 | 1 | 52,486.9 | 100% |

| Нийт дүн | 1 | 52,486.9 | 1 | 52,486.9 | **100%** |
|---|---|---|---|---|---|

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төсвийн Ерөнхийлөн захирагчийн баталсан бүтэц орон тоонд байхгүй багийн сахиул-4, сантехникч-1, олон нийтийн байцаагч-1, нийт 6 гэрээт ажилтан ажиллуулсан асуудлыг дараачийн аудитаар анхаарах нь зүйтэй гэж үзлээ.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар 1,602.3 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 1,602.3 мянган төгрөгийн 1 зөрчилд зөвлөмж өглөө.

### 5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. ***Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал***

*1.1. Илрүүлэлт:*

Мал тооллогын урамшууллын зардлаас 857.5 мянга, 2025 оны 07 дугаар сарын цалингаас 1 ажилтны 744.8 мянга, нийт 1,602.3 мянган төгрөгөөс нийгмийн даатгалын шимтгэл, хувь хүний орлогын албан татварыг суутгасан боловч, тайлангаар илэрхийлэгдээгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх заалтад "Үнэн зөв байх", 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсэгт "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ" 14.4.1 дэх заалтад "Аж ахуйн бүх ажил, гүйлгээ" гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй нь Иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байсан тул зөвлөмж өглөө.

***1.2. Өгсөн зөвлөмж:***

Цаашид Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийг хэрэгжүүлэн ажиллах.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг 2026 оны 5 дугаар сарын 05-ны өдрийн дотор Увс аймаг дахь Төрийн аудитын газарт тус тус ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 1. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Цалинг НДШ-ийн тайлан, ХХОАТ-ын тайланд | 1 | 1,602.3 | 1 | 1,602.3 | | | | | 1 | 1,602.3 | 1 | 1,602.3 |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| тайлагнаагүй байна. | | | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | | | |
| **Дүн** | 1 | 1,602.3 | 1 | 1,602.3 | | | | | | | 1 | 1,602.3 |

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| | | | | | | | | | | | | |
| Дүн | | | | | | | | | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| | | | | | | | | |
| Дүн | | | | | | | | |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| | | | | | | | | |
| | | | | | | | | |
| Нийт дүн | | | | | | | | |

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР /М.БАТСУУРЬ/

АУДИТЫН МЕНЕЖЕР /М.БАТ-АМГАЛАН/

9065555 1525010041

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР /Р.АЮУШ/

2026 оны 02 дугаар сарын 25-ны өдөр

20 УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР ӨӨРЧЛӨЛТГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ